

## НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД

*Б. Бат-Өлзий  
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*bbatulzii04@gmail.com*

*Д. Амарзаяа  
Магистр оюутан*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*amarzaya0130@gmail.com*

*Хураангуй: Хүүхдийн тусламжийн утас болон бусад сувгаар ирсэн дуудлага мэдээлэлд 72 цагийн дотор гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын дагуу гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай үйлчилгээг төлөвлөн үйлчилгээ үзүүлдэг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ямар үйлчилгээ үзүүлэхийг шийдвэрлэхэд хорооны хамтарсан багийн 2-оос дээш гишүүний хийсэн нөхцөл байдлын үнэлгээ шийдвэрлэх нөлөө үзүүлдэг учраас нөхцөл байдлын үнэлгээ үнэн бодитой хийгдэж байгаа эсэхэд шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой. Хорооны нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлын үнэлгээнд хийсэн шинжилгээний үр дүнг энэхүү өгүүлэлээрээ танилцуулж байна.*

*Түлхүүр үгс: Хорооны нийгмийн ажилтан, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, ур чадвар, үйлчилгээ*

### УДИРТГАЛ

Манай улсад хамтарсан баг байгуулах талаарх санаачилга 2003 онд гарч байсан бөгөөд хамгийн анхны эрх зүйн баримт бичиг нь Нийслэлийн Засаг даргын 2007 оны 44 тоот тушаалаар “Нийслэлийн бүх хороодод хамтарсан баг байгуулж, ажиллах” захирамж гарч байсан.<sup>1</sup> 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан “Хүүхэд хамгааллын тухай хуульд” хамтарсан баг гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг хэлнэ хуульчилсан. Гэхдээ 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд Хамтарсан баг, түүний үзүүлэх үйлчилгээг бүлэг болгон шилжүүлэн

хуульчилсан. Хамтарсан багийн үзүүлж буй үйлчилгээний талаар Японы хүүхдийг ивээх сангаас 2010, 2015, 2018 онуудад “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгааны тайлан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 онд “Хамтарсан багийн өнөөгийн байдал, ололт, амжилт тулгамдаж буй асуудал” судалгааны тайлан, Гүүд нэйтборс Олон улсын байгууллагаас “Хамтарсан багийн ажиллагаанд тулгамдаж буй асуудал” гэх мэт судалгаануудыг хийсэн. Дээрх судалгаануудад хамтарсан багийн үзүүлж буй үйлчилгээ, салбар дундын хамтын ажиллагаа, хууль дүрэм журмын хэрэгжилтийн хэрхэн хангадаг, ажлын ачаалал, тоо баримтын талаар судалсан байна. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд эрхийн зөрчлийг мэдээллэх олон сувгийг ашигладаг. Хүүхдийн тусламжийн утас болон цагдаа, олон нийт, иргэн өөрөө хамтарсан багт хандах, хамтарсан багийн гишүүд ажил үүргээ гүйцэтгэх явцдаа зөрчлийг илрүүлэх гэх мэт мэдээллийн сувгууд байна. Эдгээр ирсэн дуудлага мэдээллийн дагуу хорооны хөгжлийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Гэвч нийгмийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэргэжил, мэргэшсэн байдал, туршлагаас шалтгаалан нөхцөл байдлын үнэлгээг бүрэн гүйцэт, зөв хийж байгаа эсэх асуудалд анхаарал хандуулах зайлгүй шаардлага байна.

## **ОНОЛ, АРГА ЗҮЙ**

Хүүхэд хамгааллын тухай хуулинд “Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ” гээд 6 төрлийн хариу үйлчилгээг тусгасан байдаг. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний 10.1.2-т “нөхцөл байдлын үнэлгээ хийх” гэж заасан байдаг.

Нийгмийн ажлын үйлчилгээний эхэнд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид тулгарч байгаа асуудлын шалтгаан, нөхцөл байдалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж тухайн үйлчлүүлэгчид хэрхэн тусалж [Батхишиг А., 2008], хамтран асуудлыг шийдвэрлэх талаар судалдаг. Манай улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, хүүхэд хамгааллын тухай хуулинд болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/1201, А/178 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-д нөхцөл байдлын үнэлгээ гэж үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд

тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалтай холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг хэлнэ гэж тодорхойлсон. Хороонд ирсэн дуудлага мэдээллийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, тухайн гэр бүлд шаардлагатай, хэрэгцээнд нь тохирсон үйлчилгээ үзүүлэх нь хүүхдүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагаа юм.

А.Маслоугийн онолын үүднээс хүний бүх хэрэгцээ төрөлхийн, зөн билгийн шинжтэй бөгөөд эдгээр нь дараах шатлалтай.

- Физиологийн хэрэгцээ
- Аюулгүй байдал, хамгааллын хэрэгцээ
- Харьяалагдах ба хайрлагдах хэрэгцээ
- Өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ
- Өөрийгөө идэвхижүүлэн төгөлдөржүүлэх

Дээрх хэрэгцээг гурвалжин гэж үзвэл сууринд нь багтаж буй үндсэн хэрэгцээнүүд хангагдсаны дараа дараагийн хэрэгцээнүүдийг ухамсарлана. Хэрэгцээний ийм шатлал хүн бүрт байдаг бөгөөд уг шатлалаар хэдий чинээ өндөрт өсгөх тусам өөрийн хувийн өвөрмөц, онцлог хүн ёсны чанар, сэтгэцийн эрүүл мэндээ төдий чинээ сайн харуулах боломжтой байдаг. Хэрэгцээний шатлалд доогуур байр эзэлж байгаа хэрэгцээнүүдийн хүчин, нөлөөлөл бусдаасаа илүү байдаг. Хүн хэрэгцээний шатлалын өндөрлөгт гарсан ч гэсэн суурь хэрэгцээнүүд нь хангагдахаа больчихвол хүн эргээд хэрэгцээнийхээ шатлалын уг түвшиндээ буун ирж уг хэрэгцээгээ хангах үйл явц эхэлдэг.

Хямралын онолоор гэнэтийн хямралд орсон хүн хямралд дасан зохицох эсвэл үл дасан зохицох байдлаар хямралд хариу үйлдэл үзүүлдэг. Үүссэн нөхцөл байдал тухайн хүний даван туулах чадвараас ахадсан бол тэр хүнд стресс, хямрал илүү хүчтэй нөлөөлнө гэж үздэг. Хямрал нь 4-8 долоо хоног үргэлжлэх бөгөөд үүсгэсэн хүчин зүйлийн онцлогоос хамаарч хямрал үргэлжлэх хугацаа өөр өөр байдаг. Хямралд орсон үед нь түргэн шуурхай хямралын эсрэг үйлчилгээ үзүүлж, гарч болох сөрөг үр дагавраас аль болох эрт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай гэж үздэг. Жишээ нь хүүхдийн хүчирхийллийн талаар дуудлага мэдээлэл ирэхэд хамтарсан багаас 72 цагийн дотор нөхцөл байдлын үнэлгээ хийх нь хямралыг даван туулахад туслах үйлчилгээний тулгуур болно.

## СУДАЛГАА

Энэхүү судалгаагаар гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний ХХ04 маягтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 10 хорооны нийгмийн ажилтнуудын

2022 онд хийсэн 30 нөхцөл байдлын үнэлгээг сонгон шинжилгээ хийсэн. 10 хорооны хамтарсан багийн гишүүдийн тоог нь 5-7, 8-11 гишүүнтэй гэж хувааж хувиар авч үзэхэд 78% нь 5-7 гишүүнтэй, 22% нь 8-11 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хамтарсан багийн хуульд заасан зарим гишүүд нь байхгүй байгаа нь төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн, мэргэжлийн индекс нь таарсан байх шаардлагын дагуу хүний нөөцийн асуудалтай холбоотой байна.

Нийт 10 хорооны нийгмийн ажилтнуудын ажилласан хугацаа нь 2-6 жилийн хугацаанд ажилласан, эзэмшсэн мэргэжлийн хувьд нийгмийн ажилтан 10%, сэтгэлзүйч 10%, багш 20%, бусад мэргэжлийн 60% байна. Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний маягт ХХ04-ыг хүүхдийн эцэг эхийн мэдээлэл, гэрлэлтийн байдлын талаар мэдээллийг 100% бөглөсөн байна. Нөхцөл байдлын үнэлгээг хаана хийсэн талаарх мэдээллийг авч үзэхэд үйлчлүүлэгчийн гэрт хийсэн 70%, хорооны байранд иргэнтэй уулзаж байх үед хийсэн 20%, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хаана хийсэн нь тодорхойгүй, бичигдээгүй 10% байна.

Гэр бүлийн нөхцөл байдлын талаарх мэдээлэлд гэр бүлийн сарын орлогын хэмжээг тодорхойлоогүй тухайлбал, хөдөлмөр эрхэлдэг 2 гишүүний сарын орлогын хэмжээг тус тусад нь бичээгүй байгаа нь нийт нөхцөл байдлын үнэлгээний 60%-ийг эзэлж байна.

Гэр бүлийн удмын зураг буюу генограммын мэдээллийг хангалтгүй зурсан 20%, огт зураагүй 80% байна. Эко зураглалыг зураагүй 80%, бүрэн гүйцэт зурсан 10%, бүрэн гүйцэт зурсан 10% байгаа бөгөөд хорооны нийгмийн ажилтанд генограмм, эко зураглал хэрхэн зурах, шаардлагатай мэдээллийг бичих арга зүй дутмаг байна.

Гэр бүлийн гишүүдийн хэн нь ямар халамжийн үйлчилгээнд хамрагддаг, хэдэн төгрөг авдаг гэх мэт мэдээллийг огт бичээгүй орхисон 10%, дутмаг бичсэн 40%, бүрэн бичсэн 50% байна. Жишээлбэл 2 хүүхдийн 1 охин нь тэжээгчээ алдсаны тэтгэмж авдаг, энэ тэтгэмжийн мөнгийг хэний дансаар дамжуулан авдаг гэсэн мэдээлэл байхгүй байна.

Гэр бүлийн гишүүдийн харилцааг тодорхойлохын тулд хорооны нийгмийн ажилтнууд ямар асуумж, аргаар тодорхойлж байгаа нь тодорхойгүй байгаа бөгөөд гэр бүлийн гишүүдийн харилцааны тайлбар хэсэгт хангалттай мэдээлэл бичээгүй 80% байгаа нь тус нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж байна.

Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний төгсгөл хэсэгт ерөнхий дүгнэлт, давуу талыг хэрхэн тодорхойлж байгаа, дүгнэж бичиж байгаа нь харилцан адилгүй байна. Мөн баталгаажуулалт хийгдсэн гарын үсэг, тамга нь дутуу 50% байгаа бөгөөд нотлох баримтны шаардлага хангахгүй, үнэлгээг хийсэн эсэхэд эргэлзэх нөхцөл байдалд хүргэж байна.

## ДУГНЭЛТ

Төрийн албаны зөвлөлөөс хорооны нийгмийн ажилтан албан тушаалд шаардагдах мэргэжлийг тодорхойлон гаргасан бөгөөд үүнд эрх зүй, менежмент ба удирдахуй, нийгмийн шинжлэх ухаан, боловсролын шинжлэх ухаан, багш мэргэжлийн, нийгмийн хамгаалал, эдийн засгийн мэргэжлийг тодорхойлсон байна. Эдгээр индекст таарсан мэргэжлийн хүн хорооны нийгмийн ажилтнаар ажиллах боломжтой гэж тусгасан боловч төрийн албанд ажиллах сонирхол, цалин, ажлын ачаалал зэргээс хамаарч ажилд орохгүй байгаагаас бусад мэргэжлийн хүнийг нийгмийн ажилтнаар авч ажиллуулж байгаа нь гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх чадвар дутмаг байгаагийн нэг шалтгаан болж байна. Вассийн тодорхойлсноор нийгмийн ажилтнууд нь дараах ерөнхий чадвартай байхыг шаардана. Үүнд:

- Нөхцөл байдалд үнэлгээ хийх, судалгаа шинжилгээ хийх, ойлгон дүгнэх танин мэдэхүйн чадваруудтай байх,

- Тэмдэглэл хөтлөх, тайлан бичих зэрэг баримт хөтлөх захиргааны ур чадвартай

- Бусдыг ойлгох, өөрийгөө таних, эрх мэдлээ зөв ашиглах, янз бүрийн бүлэг хүмүүстэй харилцах, түншлэх, эерэг харилцаа холбоо тогтоох хөгжүүлэх, улмаар харилцаа холбоогоо тогтоон барих зэрэг харилцааны ур чадвартай байх

- Эрх мэдэл ба хариуцлагатай холбоотой шийдвэр гаргах чадвартай байх

- Нөөц ашиглах ба зохицуулах чадварыг тус тус эзэмшсэн байх ёстой

2022 онд хорооны нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах 4-8 цагийн сургалтыг танхимаар болон ажлын байран дээр нь зохион байгуулсан бөгөөд эдгээр сургалтуудад нөхцөл байдлын үнэлгээ хэрхэн бөглөх талаар сургалтын агуулгыг тусад нь оруулж, генограмм, эко зураглал хэрхэн зурах талаар гарын авлага, мэдээллийг түгээх, иргэнээс мэдээллийг тодруулах, түүнийг хэрхэн баталгаажуулах, нөхцөл байдлыг тогтооход гэр бүлийн гишүүдээс хэрхэн асуулт асуух зэрэг арга зүйн мэдлэгийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### **НОМ ЗҮЙ**

[1]. Мягмар О. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. Улаанбаатар, 2016

[2]. Энхтуяа С. Хүүхэд хамгааллын үндэс. Улаанбаатар, 2009

[3]. Батхишиг А., Мягмар О., Нямдорж М. Хүүхэд хамгааллын үйлчилгээ. Улаанбаатар, 2009

[4]. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/1201, А/178 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам

[5]. СБД-ийн 10-р хорооны Нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлын үнэлгээний маягтууд